



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цэргийн алба хаагчийн түр суларсан орон тоог нөхөж ажиллуулах, албан үүргийг түр хавсран гүйцэтгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга (хошууч генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (дэслэгч генерал С.Ганбямба)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (дэд хурандаа Ж.Эрдэнэсайхан)-т даалгасугай.

САЙД



Д.БАТЛУТ

1326100062

Батлан хамгаалахын сайдын 2026 оны

01 дүгээр сарын 16-ны өдрийн

01/40 дугаар тушаалын хавсралт

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТҮР СУЛАРСАН ОРОН ТООГ
НӨХӨЖ АЖИЛЛУУЛАХ, АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь цэргийн алба хаагчийн түр суларсан орон тоог нөхөж ажиллуулах болон албан үүргийг түр хавсран гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Журмыг хэрэгжүүлэхдээ алба хаагчийн хуулиар тогтоосон эрх, эрх ашиг, шатлан дэвших боломж болон цалин хөлс, нийгмийн баталгааг дордуулахгүй байх зарчмыг баримтална.

1.3.Журмын үйлчлэлд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа цэргийн алба хаагч болон офицер, ахлагчийн албан тушаалд хуульд заасны дагуу туршилтын хугацаагаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр хавсран гүйцэтгүүлж байгаа алба хаагч хамаарна.

1.4.Энэ журамд дурдсан Цэргийн алба хаагч /цаашид “алба хаагч” гэнэ/.

Хоёр. Алба хаагчийн түр суларсан орон тоог нөхөж ажиллуулах

2.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дор дурдсан үндэслэлээр алба хаагчийн түр суларсан орон тоог нөхөж ажиллуулна:

2.1.1.эрүүл мэндийн байдал, ар гэрийн гачигдал болон бусад шалтгаанаар чөлөөтэй байх хугацаа;

2.1.2.мэргэжил, мэргэшил дээшлүүлэх сургалт, дамжаанд хамрагдах хугацаа;

2.1.3.жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд харах чөлөөтэй байх хугацаа;

2.1.4.алба хаагч албан тушаалаас түр чөлөөлөгдсөн;

2.1.5.алба хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, эсхүл өөр албан тушаалд сэлгэсэн, халсантай холбоотой асуудлаар алба хаагч эрх бүхий байгууллагад өргөдөл, гомдол гаргасан, эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэр гараагүй;

2.1.6.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаа;

2.1.7.дотоод, гадаад албан томилолттой;

2.1.8.гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээ авагдсан хугацаа;

2.1.9.гэмт хэргийн улмаас хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байгаа хугацаа.

2.2.Түр суларсан орон тоонд алба хаагчийг нөхөн томилох эрх нь тухайн байгууллагын дарга, захирал, захирагчид хууль тогтоомж, тушаал, шийдвэрээр олгогдоогүй тохиолдолд томилох эрх бүхий албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлнэ. Эрх бүхий албан тушаалтан нь түр суларсан орон тоонд нөхөн томилогдох боломжтой алба хаагчийг сонгож, тухайн алба хаагчтай харилцан тохиролцсоны дагуу түр суларсан орон тоонд алба хаагчийг нөхөн томилж ажиллуулна.

2.3.Түр суларсан орон тоонд алба хаагчийг нөхөн томилох эрх нь тухайн байгууллагын дарга, захирал, захирагчид байгаа тохиолдолд ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлог, тусгай мэргэжил, ажлын туршлага болон хамгийн ойр хамааралтай чиг үүрэг гүйцэтгэдэг зэрэг үзүүлэлтийг харгалзан үзэж алба хаагчийг нөхөн томилно.

2.4.Энэ журмын 2.2, 2.3-т заасны дагуу болон салбарын хэмжээнд түр суларсан орон тоог нөхөх боломжгүй бол төрийн тусгай алба хаагчдаас, эсхүл Цэргийн албаны тухай хуулийн 19.2, 19.3-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлт болон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагаас хангасан, нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэнийг түр томилон ажиллуулж болно.

2.5.Эрх бүхий албан тушаалтан нь түр суларсан орон тоог нөхөн хангах тушаал, шийдвэрт тухайн албан тушаалд ажиллах хугацаа, албан тушаалын цалин хөлсний талаар тодорхой тусгана.

Гурав.Албан үүргийг түр хавсран гүйцэтгүүлэх

3.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд энэ журмын 2.1-д заасан үндэслэлээр алба хаагчийн албан үүргийг өөр алба хаагчтай харилцан тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр хавсран гүйцэтгүүлнэ.

3.2.Цэргийн албаны тухай хуулийн 20.1-д заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр гурваас дээш сарын хугацаагаар түр эзгүй байгаа алба хаагчийн үүргийг өөр алба хаагчаар хавсран гүйцэтгүүлж болно.

3.3.Эрх бүхий этгээд нь албан үүргийг түр хавсран гүйцэтгэгчийг сонгохдоо энэ журмын 2.2, 2.3, 2.4 дэх хэсгийг удирдлага болгон ажиллана.

3.4.Цаг үеийн нөхцөл байдал, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, гамшгийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан албан үүргийг түр хавсран гүйцэтгүүлэхээр эрх бүхий этгээд алба хаагчийг шууд томилж болно.

3.5.Түр хавсран гүйцэтгэгч нь тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлж, эрхийг эдэлнэ.

3.6.Алба хаагчийг түр хавсран гүйцэтгэгчээр томилох шийдвэрт түр хавсран гүйцэтгэх хугацаа болон эдлэх зарим бүрэн эрхийг хязгаарлах, үр дүнг бүрэн хариуцах талаар тусгаж болно.

3.7.Албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч нь хавсран гүйцэтгэх албан үүргээ болон өөрийн үндсэн ажил, албан үүргээ бүрэн хариуцна.

3.8.Алба хаагчийн албан үүргийг түр хавсран гүйцэтгэж байгаа алба хаагчид Цэргийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу албан тушаалын цалингийн 40 хүртэл хувиар урамшуулал олгоно.

3.9.Төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр хавсран гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно.

Дөрөв.Бусад зүйл.

4.1.Түр хавсран гүйцэтгэж байгаа ажлаа хангалтгүй биелүүлсэн, алдаа, дутагдал гаргасан, хохирол учруулсан, хууль тогтоомж болон энэ журмыг зөрчсөн алба хаагчид хууль тогтоомжид заасан хариуцлагыг ногдуулна.

---oOo---